



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ

᠒᠐᠒᠒ оны ᠐4 сарын 19 өдөр

Дугаар ᠕/᠒3

Мандалговь

“Тэнгисийн шүр” ХХК-тай гэрээ  
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ТУШААХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжих “Гудамж талбайн тохижилт, ногоон байгууламж” /Дундговь/-ийн гүйцэтгэгчээр шалгарсан “Тэнгисийн шүр” ХХК-тай 888,130,824 (найман зуун наян найман сая нэг зуун гучин мянга найман зуун хорин дөрөв) төгрөгөөр гэрээ байгуулсугай.

2. Батлагдсан ажлын даалгаврын дагуу чанартай гүйцэтгэн, хүлээлгэж өгөхийг “Тэнгисийн шүр” ХХК-ний захирал (М.Өсөхбаяр)-д үүрэг болгосугай.

3. Дээрх байгууллагатай гэрээ байгуулж, гэрээний дагуу хяналт тавьж ажиллахыг Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир), Газрын харилцаа, барилга хот, байгуулалтын газрын дарга (Э.Чагнаадорж), ажлын тайлан, гүйцэтгэлийг үндэслэн санхүүжилт олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (Г.Энхтайван) нарт үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ  
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



Л.ДОРЖБАТ

4822150162